

## Суралцагчийн суралцах аргад хийсэн судалгаа

Э.Батчимэг\*

Монгол Улсын боловсролын Их Сургууль,  
Дүрслэх урлаг технологийн сургууль,  
Дүрслэх урлагийн тэнхим

### Хураангуй

Үйлийн судалгааны онолд үндэслэн заах аргыг судлах, суралцангаа судлах юун дээр алдаж байгаагаа ойлгон ухаарч өөрийгөө хөгжүүлэх нь багш бидний үүрэг билээ. Цаашлаад багш бэлтгэх сургуулийн оюутнуудад өөрийн болон өрөөлийн үйлийг судлан алдаагаа засаж суралцах нь багшлах ажилдаа бүтээлчээр хандах эерэг хандлагыг бий болгоход нөлөөлнө.

ДУТС-ийн 1-р курсийн 57 оюутны суралцах аргыг дэмжих хөгжүүлэхэд чиглэсэн үйлийн судалгааг хийж боловсрууллаа. Судалгааг кейс ярилцлага болон үндсэн зургаан асуулт бүхий асуулгыг хэрэглэн баримт материалд дүн шинжилгээ хийх, харилцан ярилцах, үйлийг ажиглах аргуудад тулгуурлан хийсэн болно. Судалгаа нь суралцагчийн суралцах аргаа эмх цэгцтэй төлөвлөх үйл, өөрийн үйлийг шинжиж алдаагаа засаж сайжруулах тал дээр дутмаг харагдаж байгаа нь багш бэлтгэх сургуулийн оюутнуудын хувьд сөрөг талтай гэсэн дүгнэлтэд хүрлээ. Монголчуудын уламжлалт үйлийн судалгааг өөртөө өвөрлөсөн үйлийн явцдаа суралцахуйн практик үйл нь дүрслэх урлагийн хичээлд нэн тохирч байгаа билээ.

Ялангуяа ДУТС-ийн оюутан суралцагчдын суралцахуй нь практик үйл төдийгүй оролцоо хамтын ажиллагаа, суралцах явцад дахин дахин давтаж хийх, турших байдлаар нэг хэв шинжээс нөгөө хэв шинжид шилжин сайжруулж бүтээл гаргах байдлаар суралцах арга барилыг эзэмших нь чухал байдаг.

### Түлхүүр үг

Үйл судлал, үйлийн судалгаа, ажиглах, эргэцүүлэх, суралцах арга, үйлийн явцдаа суралцахуй.

### Удиртгал

Монголчуудын ахуй амьдрал өөрөө тэр чигээрээ үйлийн судалгаанд тулгуурлаж өдөр тутмын ажил амьдралаа шинжиж үйлийн явцдаа суралцаж ирсэн түүхтэй.

Тийм учраас нүүдэлч Монголчуудын үйлийн явцад суралцахуйн арга барилыг шинжлэн судлах хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ хэрэгцээ шаардлагын улмаас бид суралцагчийн суралцах үйл, заах аргыг судлах юун дээр алдаж, онож байгааг тодруулан шинжих, уламжлалт сурахуйн арга технологи, өв соёл, гүн ухааныг судалж өөрийн сургалтын арга боловсруулах зорилго тавьсан юм. Монголчуудын үйлийн судалгааны талаарх онолыг орчин цагийн сургалтын онол болох прагматик онол, бихевиоризмын онол, конструктивизм болон когнитивизм онолуудтай харьцуулан судалж өөрийн сургалтын үйл явцад холбон сургалтын арга зүй боловсруулан хэлэлцүүлж буй болно. Энэхүү арга нь суралцагчдад үйлийг ажиглах-эргэцүүлэх-төлөвлөх-үйлдэх гэсэн дөрвөн орчлыг төлөвшүүлэх сургалтын үйл ажиллагаа болно.

Академич Б.Жадамбаа үйлийн судалгааны квант онол бүтээлдээ “Монголчууд эрт дээр үеэс үйл судлалд “шинжлэх үгүй бол мэдэх үгүй, шиншлэх үгүй бол үнэртэх үгүй, шимэх үгүй бол амтлах үгүй” хэмээн онцгойлон анхаарч ирсэн билээ” гэж бичжээ (Жадамбаа 2016, х.44).

### Судлагдсан байдал

Үйлийн судалгааны тухай онол нь бусад дэлхий даяар түгэн дэлгэрсэн онолуудаас ялгарах онцлогтой.

- Үйл болон үйлийн судалгааны гүн нарийныг буюу утга, учир, уг чанар, ач холбогдол, түүнийг зайлшгүй эрхлэх хэрэгцээ шаардлагыг бүхэлд нь тодруулах боломж олгодог.
- Бусад онолуудаас нэг шат гүн буюу тэдгээрийн маш гүн нарийныг илрүүлдэг. Тухайлбал, үйлийн судалгааны тухай эдүгээ цагийн онолууд алив бүхний мөн чанарыг тодруулан зүй тогтлыг тайлбарлан тодорхойлж байгаа бол Монголчуудын үйлийн судалгааны онол тэрхүү зүй тогтлын маш гүн нарийн нь тэдгээрийн мөн чанарын

\*Холбоо барих зохиогч: batchimeg@msue.edu.mn

ёсонд, өөрөө болсон ёсонд байдаг болохыг хэлж өгдөг.

- Монголчуудын үйлийн судалгааны онолын үндэслэлүүд нь өнөөгийн түүний талаарх олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бүх онолуудыг болон тэдгээрийг баяжуулан хөгжүүлэх санаануудыг өөртөө агуулсан мета шинж төрхтэй гэж үзсэн байна (Жадамбаа, 2016, х.11).

Швейцарийн эрдэмтэн Ж.Пиаже 1960 оны үед хүний хөгжлийн сэтгэлзүйн тухай асуудлыг үндсээр нь өөрчлөхдөө дөрвөн том дүгнэлт хийсний нэг нь “Хүний хөгжил бол биологийн суурь чадавх болон туршлага” гэсэн хоёр зүйлийн үр дүн байна гэж тодорхойлсон байдаг (Баярмагнай ба бус., 2018, х.11) гэжээ. Үүнээс үзэхэд аливаа зүйлийг сурахад олон дахин давтаж хийж үзсэний үр дүнд туршлага хуримтлуулж суралцан өөрийн арга барилыг бий болгосноор мэдлэгийн бүтцээ өөрчилж сайжруулан суралцах үйл явц явагдаж хүн хөгждөг гэж үзвэл “Хүн мэдлэгийг бусдаас дамжуулан хүртдэггүй харин өөрөө өөртөө зохиомжлон бүтээдэг” гэсэн ойлголттой яв цав нийцэж байна. Үүнтэй уялдсан тодорхойлолтыг Н. Ф. Тализына “Танин мэдэх үйл ажиллагааны арга барил өөртөө тодорхой мэдлэгийг агуулж байдаг бөгөөд энэ нь арга барил буюу үйлийн бүрэлдэхүүнд урьдчилан багтаж төлөвшиж байдаг” (Талызина, 1982, х. 234) гэж тодорхойлжээ. Түүнчлэн нэрт гүүш Инжиннашийн “Зураг зурж сурахад гурван зүйлийн зам буй”. Нэгэн зүйл нь: “Багшийг дагаж ёсоор зурах”, өөр нэгэн зүйл нь: “Бодитойг дагаж адил зурах”, гурав дах зүйл нь: “Өөрийн сэтгэгдлээс төрөгдүүлэн зурах” хэмээн сургасан байдгаас өөрийн сэтгэгдлээс төрөгдүүлэн зурах нь эрхэм хэмээсэн нь Монголчуудын уламжлалт үйлийн явцад суралцахуйн онолын бас нэг үндэс болох юм. Түүнчлэн судлаач Ч.Пүрэвдорж өөрийн бүтээлдээ “Монгол нүүдэлчин бол зүгээр амьдраад байдаггүй, харин түүнд суралцаж байдаг. Учир нь байгалиас заяасан угийн сониуч чанараар хүний оюун ухаан ямагт элдэв асуулт тавьсаар байх бөгөөд энэ нь түүний информал аргаар суралцах эх үндэс болдог” (Ч. Пүрэвдорж, эмхт. 2014, х. 24) гэжээ. Энэ арга нь амьдрал дээр алив зүйлийг ахин дахин туршиж үзэж үр дүнг өмнөхтэйгөө харьцуулан ажиглаж, эргэцүүлж, төлөвлөж дахин сайжруулж суралцдаг нь үйлийн явцдаа суралцахуй мөн билээ. Иймд “багш нар ер нь хэн боловч практик үйл ажиллагаагаа судлан улам сайжруулах арга хандлагаа тодорхойлох хэрэгтэй болдог” (Пүрэвдорж, 2014, х.427) гэж хэлсэнтэй санал нэг байна.


## Судалгааны арга зүй

ДУТС-ийн 1-р курсын 57 оюутан судалгаанд хамрагдсан. Судалгааг кейс ярилцлага болон үндсэн зургаан асуулт бүхий асуулгыг хэрэглэн баримт материалд дүн шинжилгээ хийх, харилцан ярилцах, үйлийг ажиглах аргуудад тулгуурлан хийсэн болно. Үйлийн судалгааны ажиглах-эргэцүүлэх-төлөвлөх-үйлдэх гэсэн өөрийн үйлийг судлах нэгэн орчлын загвараар хамгийн өндөр жинтэй байгаа үйлийг тодруулах үйл явцыг судалсан.

## Судалгааны үр дүн


Судалгаанд үндсэн зургаан асуулгыг боловсруулж оюутнуудын суралцах аргыг тодруулах үйлийг дараах графикт үзүүллээ.

График 1  
Оюутнуудын бие дааж сурсан зүйлс



Дээрх асуултад зураг зурах-12, юм оёх-нэхэх-13, сийлбэр-7 хүүхдүүд гар урлалын зүйлүүдийг илүүтэйгээр сонгосон нь ДУТС-ийн оюутнуудын хувьд мэргэжил сонголттой холбоотой байна. Эдгээр сонгосон нэг зүйл дээр нь үндэслэн яаж сурсан тухай суралцах аргыг судлахад хүний хийж байгаа зүйлээс ажиглаж сурсан гэх бөгөөд энэ нь үйлийн судалгааны онолын хувьд нэг циклээр дуусаад байгаа бөгөөд үүнийгээ хийгээд сурчихсан гэж эндүү ташаа ойлголттой байгаа нь судалгаанаас ажиглагдлаа. Эргээд өөрийн хийснийг ажиглан засаж сайжруулах тал дээр ажиллаж 2-3 болон 4 удаа хийхэд суралцагч бүрэн сурсан байдаг. Иймээс манай оюутнууд өөрийн үйлийг эргэн ажиглаж сурах нь суралцах аргыг сайжруулж үнэн бодитой мэдлэг бүтээхэд чиглэгдэнэ.

График 2




3. График 2т сонгосон нэг зүйлээ ямар алхмаар хийсэн бэ? гэсэн асуултад хүүхэд бүр буруу хариулсан нь яаж сурсан алхмаа мэдэхгүй байсантай холбоотой. Өөрийн сурсан зүйлээ ажиглах, үйлдэх гэсэн 2 алхмаар хийж сурсан 35 оюутан байна. Үүнээс үзэхэд сурсан нэг зүйлийнхээ талаар яаж сурснаа алхмаар нь бичиж мэдэхгүй хэт ерөнхийлж үйл ажиллагааны дарааллыг бичсэн байснаас 34 хүүхэд ажиглаж байгаад хийж сурсан гэж хариулсан бол мөн л 35 хүүхэд нь ажигласныхаа дараа шууд хийж сурсан гэсэн хариултаас харахад ажиглаад хийсэн байгаа нь эргэцүүлж бодох, төлөвлөх гэсэн 2 орчил нь хангалтгүй, өөрийн сурсан зүйлдээ эргээд сайжруулалт хийдэггүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Зураг зурж сурсан гэх оюутнуудын зурсан зураг, зурж буй үйлийг ажиглахад зурах ур чадвар хангалтгүй байсан нь суралцах арга нь дутмаг байгаа нь энэхүү графикаар батлагдаж байна.

4. Аливааг хийхдээ ажиглах, эргэцүүлэх, төлөвлөх, үйлдэх алхмыг хийдэг үү?

Гэсэн асуултад судалгаанд хамрагдсан хүүхдүүд бүгдээрээ хийдэг гэсэн хариултыг өгөөд байна. Үүнээс үзэхэд гуравдугаар асуулттай нийцэхгүй байгаа бөгөөд энэ нь ямар алхмаар суралцаж байгаагаа бүрэн ухамсарлаагүй байна. Иймд дээрх 4 орчил нь цогцоороо байх нь зөв суралцах аргыг эзэмших үйл ажиллагаа болох бөгөөд нөгөө талаасаа бүтээлчээр хандах хандлагыг бий болгоход нөлөөлнө. Зургийн ангийн оюутнуудын дийлэнх нь зурсан зургаа дахин зурж дээрх 4 алхмыг хийхгүй байсан нь сурахуйгаа төлөвлөн зохион байгуулах арга төлөвшөөгүй байна.

График 3



5. График 3-т хэдэн удаагийн оролдлогоор хийсэн бэ? асуултанд өөрийн сурсан зүйлийг ажиглаж сайжруулсан-2 хүүхэд байсан нь нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн суралцах арга дутуу төлөвшсөн байна. Хэдийгээр сурсан гэх боловч үнэндээ сайн сураагүй, эргэж сайжруулах,

өөрийн үйлийг ажиглах яаж сайжруулах тухай эргэцүүлж боддоггүй нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа. Энэ нь График-3 үзүүлсэн 5-10 удаа буюу түүнээс дээш хийж сурсан баримтаас харахад батлагдаж байна.

6. Өөрийн ямар нэг зүйлийг сурсан аргаа бусдад яаж эзэмшүүлэх вэ? асуултанд өөрийн биеэр хийж үзүүлж дараа нь өөрөөр нь хийлгэнэ гэсэн хариултыг дийлэнх нь өгсөн байгаа нь ажиглуулаад дараа нь хийлгэнэ гэсэн санаа бөгөөд энэ нь ажиглах үйлдэх 2 зарчмаар сургаж байгаа нь ажиглагдлаа. Үүнээс үзэхэд график 2-т үзүүлсэн баримттай нийцэж байгаа нь суралцах аргын хувьд төлөвшөөгүй байгаа бөгөөд өөрөө яаж сурсан тэр зарчмаар бусдад зааж байгаа нь сургалтанд муугаар нөлөөлнө гэж үзэж байна.

Хүний сурах үйл ажиллагаа нь өрөөлийн үйлээс эхтэй нар зөв эргэсэн ажиглах- эргэцүүлэн бодох- төлөвлөх- үйлдэх гэсэн орчилд эргэлддэг гэдгийг дахин тайлбарлаж өгсөн. Үүний дараа дахин сонгосон нэг зүйлээ ямар алхамаар хийсэн бэ? гэдэг асуултын хариултыг сайжруулах тал дээр дахин бичүүлсэн боловч эргэцүүлэх, төлөвлөх хоёрыг ойлгосон боловч яаж сурсанаа алхамаар нь бичиж чадахгүй хэвээр байсан. Яагаад оюутнууд сурсан зүйлийнхээ алхамыг бичиж чадахгүй байгаа тал дээр эргэцүүлж бодоод кейс хийж харьцуулж үзсэн.

#### Асуулга 2 Кейс ярилцлага

Кейс: 1. 11 настай хүүгээс хэнээр ч заалгаагүй сурсан зүйл байна уу гэж асуухад байна гээд нэлээдгүй зүйлийг нэрлэсэн. Тодорхой хэдийг дурьдахад дугуй унаж сурсан, ролик унаж сурсан, коньки унаж сурсан гэх мэт. Үүнээсээ дугуйг яаж унаж сурсанаа хэлнэ үү гэхэд нэг бүрчлэн нэрлэж байсан төдийгүй өөрийн үйлийг ажиглаж сайжруулсаар чөлөөтэй унадаг болсон тухайгаа, ролик унаж сурсанаа ч ярисан юм.

Ингээд судлаачын зүгээс 11 настай хүүхэд хариулаад байхад оюутнууд яагаад алхамыг бичиж чадахгүй байгааг нэлээн эргэцүүлсний үндсэн дээр оюутнаас кейс судалгаа авч харьцуулж үзэхээр болсон юм.

Кейс:2. Оюутан А-гаас хэнээр ч заалгаагүй сурсан зүйл байна уу? гэж асуухад олон зүйлийг нэрлэсэн. Интернетээс бугуйвч шүлжиж сурсан. Шүлжсэнийхээ дараа гартаа зүүхэд орохгүй байсан. Дахин ажиглалт хийсний үндсэнд сунадаг сатууркаар шүлжихийг ойлгон 4-5 удаа сүлжсэний дараа сайхан сүлжиж сурсан гэж хариулсан юм.

Энэ кейсээс оюутан А-гийн бугуйвч шүлжиж сурсан арга нь эхлээд ажиглаад, эргэцүүлээд үйлдсэн, дараа нь өөрийн үйлийг ажиглаж сайжруулаад 4-5 удаа хийсний үндсэнд сүлжиж сурсан нь Оюутан А-гийн хувьд төлөвлөх алхамыг орхигдуулсан байна. Нарийвчилан алхамчилж сурсан аргаа хэлж мэдэхгүй байгаа юм.

Ингээд 2 кейсийг харьцуулж үзэхэд бага насандаа хүүхэд юмыг сурахдаа их нарийвчилж өөрийнхөө сурах үйлийг ажиглаж алхамчилж сайжруулаад сурсан байхад оюутан А-гийн хувьд ерөнхийд нь ажиглаад эргэцүүлж хийсэн бөгөөд төлөвлөх алхамыг орхигдуулсан бөгөөд нарийн алхамчилж сурсан аргаа хэлж мэдэхгүй байсан.

Үүнээс үзэхэд суралцагчдын суралцах арга нь “Арга” буюу динамик тал “Билэг” буюу статик талаараа хуваагдан салангад суралцах үйл явц явагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

### Дүгнэлт

Судалгааныхаа үр дүнг задлан шинжилж нэгтгэн дүгнэсэнийхээ үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна.

1. Судалгаанаас үзэхэд суралцагчийн суралцах арга эмх цэгцтэй төлөвлөх үйл, өөрийн үйлийг шинжиж алдаагаа засаж сайжруулах тал дээр дутмаг харагдаж байгаа нь багш бэлтгэх сургуулийн оюутнуудын хувьд сөрөг талтай. Иймээс цаашид багш бүр хичээлийг заахдаа суралцагчдад хичээлийг өөрөөр нь ажиглуулж, эргэцүүлэх, төлөвлөх, үйлдэх гэсэн 4 орчыг эзэмшүүлж заах нь зүйтэй байна.
2. Сургалтын явцад хүүхдийн төрөлх суралцах арга барил алдагдаад сурсан л гээд байгаа болохоос сайн сурсан уу? гэдэгт эргээд өөртөө ажиглалт хийж нарийвчилж үзэхгүй орхигдуулж байна. Иймээс хүүхдийн сурах аргыг төлөвшүүлэхэд цэцэрлэг болон ЕБС-ын түвшинд анхаарч үзэх шаардлагатай байна.
3. Хүүхэд бага насандаа өөрийн төрөлх суралцах арга нь ажиглаж эргэцүүлж, төлөвлөх, үйлдэх, мөн өөрийн үйлээ ажиглаад цаашид сайжруулаад сурч байгаа нь кейс судалгаанаас харагдаж байна. Харин оюутан болсоны дараа өөрийн сонирхолтой зүйлд илүү идэвхтэй суралцаж алхам бүрийг ажиглаж сайжруулж сурч байна.

### Ном зүй

- Баярмагнай, З., Цэдэн-Иш, Д., Ариунболд, А., Нацагдорж, О., Галбадрах, Б., Нэргүй, А. (2018). *Бага боловсролын дүрслэх урлаг сургалтын арга зүй-1*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Жадамбаа, Б. (2016). *Үйлийн судалгааны квант онол*. Улаанбаатар: Гэрэл судар.
- Нандинцэцэг, Ё. (2014). Тогтолцооны хандлага ба боловсролын судалгаа. *Эрдэм шинжилгээний эмхэтгэл*. Улаанбаатар: Битпресс.
- Пүрэвдорж, Ч (2014). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Талызина, Н.Ф. (1982). *Мэдлэг эзэмших үйл ажиллагааг удирдах нь*. Улаанбаатар: Д.Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинат.

## A study on students' learning techniques

Batchimeg.E\*

Department of Fine Arts

School of Fine Arts and Technology

Mongolian National University of Education

---

### Abstract

The paper mainly discusses about how teachers can develop themselves while applying action research theories into their teaching actions; and how student teachers of Teacher Education Institution can develop their attitudes towards their teaching actions. The study was conducted among 57 first-year art students from School of Fine Arts and Technology, Mongolian National University of Education. The methodological overview of the study includes the actions such as pre-printed questionnaire, cases, focus group discussion, document analysis, conversation, and action observation. The findings of the study show that students were unable to plan their learning actions, to analyze one's actions, and to correct their bad learning habits. It proves that the practical activities of Mongolian traditional action research which is the learning through learning is the most appropriate to use at Fine Arts lesson. More importantly, the art students must acquire practical learning skills while cooperating with one another, re-doing their actions through their learning, and re-applying their skills through observation. These are the smooth shift from one action to another. Therefore, it is necessary to develop students' attitudes based on the observation of their learning actions (Purevdorj, Ch., 2014:427).

### Keywords

Action research, observe, reflect, learning techniques, learning through learning

---

---

\* Corresponding author: batchimeg@msue.edu.mn